



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/489

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.4, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хархорин, Хужирт сумдад Коронавирус халдвар (ковид-19) цар тахлын голомтын тархалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ойрын хавьтлуудыг тусгаарлахтай холбогдон гарсан тусгаарлан ажиглах байрны зардалд 40,710,000 (дөчин сая долоон зуун арван мянга) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх 40,710,000 (дөчин сая долоон зуун арван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100933

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны .....  
 дугаар сарын ...-ны өдрийн ..... дугаар  
 захирамжийн хавсралт



**ХАРХОРИН, ХУЖИРТ СУМДЫН КОРОНАВИРУС ХАЛДВАР (КОВИД-19)  
 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЗАРДЛЫН ТООЦОО**

д/д	Зардлын зүйл анги	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Зардлын мөнгөн дүн
<b>1. Хархорин сум</b>					
1	Тусгаарлан ажиглах байранд тусгаарласан хүмүүсийн ор хоногийн зардал ("Тумбааш" зочид буудал)	Ор/хоног том хүн	269	50,000	13,450,000
2	Тусгаарлан ажиглах байранд тусгаарласан хүмүүсийн ор хоногийн зардал ("Заяа" зочид буудал)	Ор/хоног том хүн	315	50,000	15,750,000
3	Тусгаарлан ажиглах байранд тусгаарласан хүмүүсийн ор хоногийн зардал (Сургуулийн дотуур байр)	Ор/хоног том хүн	133	20,000	2,660,000
	<b>Дүн</b>				<b>31,860,000</b>
<b>2.Хужирт сум</b>					
	Тусгаарлан ажиглах байранд тусгаарласан хүмүүсийн ор хоногийн зардал (Хужирт рашаан сувилал ХХК)	Ор/хоног том хүн	177	50,000	8,850,000
	<b>Дүн</b>				<b>8,850,000</b>
	<b>Нийт дүн</b>				<b>40,710,000</b>

